



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг:  
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим  
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 99125777 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.01.21 № 1/44  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 7.2 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 14.9 сая төгрөгийн хөрөнгийг сумын ОНХС хөрөнгөөр худалдан авч бүртгэлд тусган, тайлант оны эцэст 19.6 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлжээ.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 8 хөтөлбөрийн хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 95 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>35,559,461.9</u></b>	<b><u>114,597,930.3</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,066,598.1	70,543,981.6
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1,066,598.1	70,543,981.6
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1,066,598.1	70,543,981.6
31211	Төрийн сангийн харилцах	1,066,598.1	70,543,981.6
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	205,280.3	445,635.2
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	67,780.3	308,135.2
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	137,500.0	137,500.0
3351	Байгууллагаас авах авлага	137,500.0	137,500.0
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,000,000.0	1,000,000.0
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	1,000,000.0	1,000,000.0
34713	Цалингийн урьдчилгаа	1,000,000.0	1,000,000.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	33,287,583.5	42,608,313.5
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	575,850.0	437,000.0
35130	Эм боох материал	575,850.0	437,000.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,711,733.5	42,171,313.5
35410	Бичиг хэргийн материал	789,500.0	325,000.0
35420	Аж ахуйн материал	15,396,573.5	17,387,773.5
35450	Барилгын засварын материал	200,000.0	200,000.0
35460	Хүнсний материал	16,325,660.0	19,645,690.0
35470	Бусад хангамжийн материал	-	4,612,850.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>737,258,571.0</u></b>	<b><u>731,449,365.4</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	737,258,571.0	731,449,365.4
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	723,517,721.2	717,822,765.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	782,810,440.0	782,810,440.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(96,103,884.9)	(117,621,811.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,929,827.0	95,089,827.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,578,482.3)	(63,537,836.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,914,482.8	50,234,480.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,125,639.4)	(31,823,312.6)
39217	Ном	2,670,978.0	2,670,978.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,740,849.8	13,626,600.0
39301	Програм хангамж	587,000.0	587,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(472,750.2)	(587,000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,626,600.0	13,626,600.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>772,818,032.9</u></b>	<b><u>846,047,295.6</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>987,138.5</u></b>	<b><u>739,775.0</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	987,138.5	739,775.0
<b>413</b>	<b>Өглөг</b>	987,138.5	739,775.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	583,179.4	55,169.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	325,959.1	237,696.0

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	78,000.0	446,910.0
41361	Байгууллагад төлөх өглөг	-	446,910.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	78,000.0	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>771,830,894.4</b>	<b>845,307,520.7</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	771,830,894.4	845,307,520.7
511	Засгийн газрын хувь оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан/	190,972,543.0	190,972,543.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	223,642,401.8	297,119,028.1
51210	Өмнөх үеийн үр дүн	223,642,401.8	223,642,401.8
51220	Тайлант үеийн үр дүн	-	73,476,626.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,215,949.6	357,215,949.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>772,818,032.9</b>	<b>846,047,295.6</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>402,254,100.0</b>	<b>593,354,200.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,000,000.0</b>	<b>22,160,000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,000,000.0	22,160,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,000,000.0	22,160,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,000,000.0	22,160,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>387,254,100.0</b>	<b>571,194,200.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	327,478,700.0	523,774,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	327,478,700.0	523,774,800.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	59,775,400.0	47,419,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,775,400.0	47,419,400.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>406,929,608.2</b>	<b>519,877,573.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>406,929,608.2</b>	<b>519,877,573.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	406,919,802.2	517,383,383.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	248,151,702.9	327,955,670.9
210101	Үндсэн цалин	197,825,511.4	246,582,818.9
210102	Нэмэгдэл	39,683,720.6	70,717,704.0
210104	Урамшуулал	10,642,471.0	10,655,148.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,914,708.7	47,566,640.3
210201	Тэтгэврийн даатгал	23,853,715.4	28,727,031.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,298,338.6	3,741,603.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,805,070.8	2,993,062.9
210204	Ажилгүйдлийн даатгал	444,903.1	743,414.4
210205	Эрүүл мэндийн даатгал	4,512,680.8	11,361,528.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,103,181.5	46,380,136.9
210301	Гэрэл, цахилгаан	2,839,181.5	3,626,436.9
210302	Түлш, халаалт	42,964,070.0	42,503,000.0
210303	Цэвэр, бохир ус	299,930.0	250,700.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,513,200.0	1,508,000.0
210401	Бичиг хэрэг	1,018,700.0	1,091,000.0
210402	Тээвэр, шатахуун	1,494,500.0	417,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	43,028,389.0	50,767,820.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,293,350.0	160,850.0

210502	Хоол, хүнс	41,735,039.0	50,606,970.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	425,000.0
210604	Урсгал засвар	-	425,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	722,000.0	805,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,000.0	805,700.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,486,620.1	41,974,415.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,905,400.0	12,920,160.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,004,000.0	1,085,050.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,577,220.1	27,969,205.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,806.0	2,494,190.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	2,492,190.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,492,190.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	9,806.0	2,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,806.0	2,000.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(4,675,508.1)</b>	<b>73,476,626.3</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(4,675,508.1)</b>	<b>73,476,626.3</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	223,642,401.8	771,830,894.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	223,642,401.8	771,830,894.4
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	74,340,935.6	74,340,935.6
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	297,983,337.4	846,171,830.0
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	297,983,337.4	846,171,830.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	297,983,337.4	846,171,830.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	73,476,626.3	73,476,626.3
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543.0	357,215,949.6	371,459,963.6	919,648,456.2

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>387,254,100.0</b>	<b>571,194,200.0</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>387,254,100.0</b>	<b>571,194,200.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	327,478,700.0	523,774,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	327,478,700.0	523,774,800.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	59,775,400.0	47,419,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,775,400.0	47,419,400.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>386,187,501.9</b>	<b>501,716,816.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>386,187,501.9</b>	<b>501,716,816.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>386,177,695.9</b>	<b>499,222,626.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	255,857,595.9	330,988,376.5

210101	Үндсэн цалин	200,987,567.2	243,307,679.9
210102	Нэмэгдэл	43,742,825.5	77,565,253.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,900.0	-
210104	Урамшуулал	10,967,303.2	10,115,443.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,620,400.0</b>	<b>45,056,300.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,449,900.0	29,654,300.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,517,200.0	3,850,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,059,800.0	3,080,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	508,500.0	770,300.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,085,000.0	7,701,200.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,196,300.0</b>	<b>46,468,400.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,292,300.0	3,714,700.0
210302	Түлш, халаалт	42,504,070.0	42,503,000.0
210303	Цэвэр, бохир ус	399,930.0	250,700.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,469,400.0</b>	<b>53,844,000.0</b>
210502	Хоол, хүнс	41,469,400.0	53,844,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>160,000.0</b>	<b>949,000.0</b>
210604	Урсгал засвар	160,000.0	949,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.0</b>	<b>805,700.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.0	805,700.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,282,000.0</b>	<b>21,110,850.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,082,000.0	18,582,850.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.0	2,528,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,806.0</b>	<b>2,494,190.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>2,492,190.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,492,190.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>9,806.0</b>	<b>2,000.0</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,806.0	2,000.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,066,598.1</b>	<b>69,477,383.5</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,066,598.1</b>	<b>69,477,383.5</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,066,598.1</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,066,598.1</b>	<b>70,543,981.6</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	572,260,798.1	501,716,816.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	572,260,798.1	501,716,816.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	569,413,798.1	499,224,626.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	393,299,698.1	330,988,376.5
210101	Үндсэн цалин	269,712,300.0	243,307,679.9
210102	Нэмэгдэл	113,682,198.1	77,565,253.1
210104	Урамшуулал	9,905,200.0	10,115,443.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49,162,100.0</b>	<b>45,056,300.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,430,500.0	29,654,300.0

210202	Тэтгэмжийн даатгал	3,932,900.0	3,850,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,145,900.0	3,080,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	786,700.0	770,300.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,866,100.0	7,701,200.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,469,400.0	46,470,400.0
210301	Гэрэл, цахилгаан	3,565,400.0	3,714,700.0
210302	Түлш, халаалт	42,504,000.0	42,503,000.0
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	252,700.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	57,419,000.0	53,844,000.0
210502	Хоол, хүнс	57,419,000.0	53,844,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	950,000.0	949,000.0
210604	Урсгал засвар	950,000.0	949,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	876,000.0	805,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	876,000.0	805,700.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,237,600.0	21,110,850.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,609,600.0	18,582,850.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,628,000.0	2,528,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,847,000.0	2,492,190.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,847,000.0	2,492,190.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,847,000.0	2,492,190.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	572,260,798.1	571,194,200.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	524,841,398.1	523,774,800.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	524,841,398.1	523,774,800.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	47,419,400.0	47,419,400.0
132001	Орон нутгийн төсвөөс	47,419,400.0	47,419,400.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,066,598.1</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>70,543,981.6</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 542.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 542.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоолоо. Залруулсан алдаа байхгүй болно.

### 3.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Ур чадварын нэмэгдлийг тушаалаар олгохдоо шалгуур үзүүлэлтээс хэтрүүлэн 542.0 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, “Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалт”, “Боловсрол шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А10/9 дугаартай тушаал”-ын 10 дугаар заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Залруулагдаагүй 1 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 1 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 542.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт өгсөн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	Ур чадварын нэмэгдлийг тушаалаар олгохдоо шалгуур үзүүлэлтээс хэтрүүлэн илүү тооцон олгосон.	1	542.0	1	542.0						
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>542.0</b>	<b>1</b>	<b>542.0</b>						

#### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТК								
5	ТЕЗ								
	<b>Нийт</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

